



**АТАР-ӨРГӨӨ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 21 өдөр

№ 26/04

Улаанбаатар хот

**“АТАР ӨРГӨӨ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

“Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.3, 60.4, 67 дугаар зүйлийн 67.1, Компанийн дүрмийн 7.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, ТУЗ-ийн 2026 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Атар Өргөө” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 08:00 цагт компанийн байр, /Хан уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө-20, Атар Өргөө Хувьцаат компанийн байрны хурлын танхим/-д хуралдуулсугай.

2. “Атар Өргөө” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:

- Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт
- Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан
- Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөөг батлах
- ТУЗ болон ТУЗ –ийн гишүүдийг сонгох
- ТУЗ болон ТУЗ –ийн гишүүдийн цалин, урамшууллын дүнг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах
- Ногдол ашгийн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн саналыг хэлэлцэн, батлах
- Бусад

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын даргад

Б.Мөнхдалай

ТУЗ-ийн дарга

Гишүүн

Д.Долзодмаа

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан:

- Мэдэгдлийг холбогдох баримт бичгийн хамт 2026 оны 03 дугаар сарын 24-ний дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх,
- Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2026 оны 03 дугаар сарын 26-ны дотор олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр /өдөр тутмын 2-с доошгүй сонин/ болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар мэдээлэх
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тэдгээрийн танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төсөл болон санал авах хуудсыг үнэт цаасны брокер диллерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2026 оны 03 дугаар 26-ны дотор хүргүүлэх,
- Дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Б.Мөнхдалайг, Тооллогын комиссын даргаар Ц.Энхтүвшинг, гишүүдээр А.Бадамгарав, О.Цэрэнпунцаг нарыг тус тус томилсугай.

6. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг энэхүү тогтоолын 01-р хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд танилцуулах асуудлыг 02-р хавсралтаар, ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар “Санал авах хуудас”-ыг 03-р хавсралтаар тус тус баталсугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр бүртгэж, саналыг “Санал авах хуудас”-аар авахаар тогтоосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГААС



Б.МӨНХДАЛАЙ